



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 286,190,000 (хоёр зуун наян зургаан сая нэг зуун ерэн мянга) төгрөгийн балансын үнэ, 38,158,666.65 (гучин найман сая нэг зуун тавин найман мянга зургаан зуун жаран зургаан төгрөг, жаран таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөлд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн зохицуулагч Х.Болор-эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3 Автомашиньг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002582

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 09 дугаар сарын 08 өдрийн
 201 дугаар тогтоолын хавсралт

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, “ ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ” ТӨСӨЛД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны нэр, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд-Круйзер 200, улсын дугаар 0374 УНУ	2021	286,190,000.00	38,158,666.65	248,031,333.35
Нийт дүн			286,190,000.00	38,158,666.65	248,031,333.35
			(хоёр зуун наян зургаан сая нэг зуун ерэн мянга)	(гучин найман сая нэг зуун тавин найман мянга зургаан зуун жаран зургаан төгрөг таван мөнгө)	(хоёр зуун дөчин найман сая гучин нэгэн мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин таван мөнгө)